



ЭРЧИМ ХҮЧНИЙ ЗОХИЦУУЛАХ ХОРОО

Ж.Самбуугийн гудамж-30, Бага тойруу,
Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар 14201
Утас: 32-01-26, Факс: (976-11) 31-93-35,
E-mail: info@erc.gov.mn

2023.03.23 № 4/302
танай _____-ны № _____-т

УС ДУ ОНӨААТҮГ-ЫН ЗАХИРАЛ Б.ГАНЗОРИГ ТАНАА

Эрчим хүчний зохицуулах хорооны 2023 оны 2 дугаар сарын 16-ны өдрийн "Тариф батлах тухай" 154 дүгээр тогтоолыг Захиргааны ерөнхий хуулийн дагуу 67.2, 67.7-д заасны дагуу захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд бүртгэгдсэн тул Эрчим хүчний тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2 дахь хэсэгт заасны дагуу мөрдөж ажиллана уу.

АЖЛЫН АЛБАНЫ
ДАРГА



Б.БОЛОР-ЭРДЭНЭ

220004289



Захиргааны хэм хэмжээний
актын улсын нэгдсэн бүртгэлд
2023 оны 03 сарын 14-ны
өдрийн 6.17.8 дугаарт бүртгэв.

ЭРЧИМ ХҮЧНИЙ ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2023 оны 02 сарын 16 өдөр

Дугаар 154

Улаанбаатар хот

Тариф батлах тухай

Эрчим хүчний тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.4, 9.2 дахь хэсэг, Захиргааны ерөнхий хуулийн 67 дугаар зүйлийн 67.2 дахь хэсгийг тус тус үндэслэн Эрчим хүчний зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. "Ус Ду" ОНӨААТҮГ-аас Говьсүмбэр аймгийн Сүмбэр сумын хэрэглэгчдэд борлуулах дулааны эрчим хүчний тарифыг хавсралтаар баталсугай.

2. Баталсан тарифыг захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд бүртгэж, "Захиргааны хэм хэмжээний актын эмхэтгэл"-д нийтлэгдсэн өдрөөс эхлэн мөрдөж ажиллахыг "Ус Ду" ОНӨААТҮГ (Б.Ганзориг)-т үүрэг болгосугай.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Ажлын алба (Б.Болор-Эрдэнэ)-нд даалгасугай.

4. Энэ тогтоолыг баталсантай холбогдуулан Эрчим хүчний зохицуулах хорооны 2021 оны 10 дугаар сарын 14-ний өдрийн "Тариф батлах тухай" 470 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА

ЗОХИЦУУЛАГЧ

ЗОХИЦУУЛАГЧ

ЗОХИЦУУЛАГЧ



Э.ТҮВШИНЧУЛУУН


П.ТОВУУДОРЖ

Л.ДАШМЯГМАРЖАВ

Ц.НОРОВЖАМЦ



Эрчим хүчний зохицуулах хорооны
2023 оны 02 дугаар сарын 16-ны өдрийн
154 дүгээр тогтоолын хавсралт



**“Ус Ду” ОНӨААТҮГ-ААС ХЭРЭГЛЭГЧДЭД
БОРЛУУЛАХ ДУЛААНЫ ЭРЧИМ ХҮЧНИЙ ТАРИФ**

Говьсүмбэр аймгийн Сүмбэр сумын хэрэглэгчдэд борлуулах дулааны эрчим хүчний тариф (НӨАТ-гүй)-ыг ангиллаас нь хамааруулан төлбөр тооцох үзүүлэлтийн нэгжид дараах байдлаар тогтооно:

№	Хэрэглэгчийн ангилал	Хэмжих нэгж	Тариф (НӨАТ-гүй)
1	Төсөвт байгууллагын эзлэхүүнээр тооцох халаалт	Төг/м³	2,688.0
2	Төсөвт байгууллагын хэмжүүрээр тооцох халаалт	Хувьсах	Төг/ГЖ 31,386.6
		Тогтмол	Төг/м³ 1,851.5
3	Үйлдвэр, аж ахуйн нэгж байгууллагын эзлэхүүнээр тооцох халаалт	Төг/м³	1,815.0
4	Үйлдвэр, аж ахуйн нэгж байгууллагын хэмжүүрээр тооцох халаалт	Хувьсах	Төг/ГЖ 21,193.0
		Тогтмол	Төг/м³ 1,250.2
5	Төсөв, ҮААНБ-ын хэрэгцээний халуун ус халаасан дулаан	Төг/м³	5,120.0
6	Орон сууцны халаалт (оюутны байр, подваль, “00”-ын ерөөний халаалт хамаарна) талбайгаар	Төг/м²	800.0
7	Орон сууцны халаалт	Хувьсах	Төг/ГЖ 9,341.3
		Тогтмол	Төг/м³ 551.0
8	Ахуйн хэрэгцээний халуун ус халаасан дулаан	Хүний тоогоор	Төг/хүн 4,000.0
		Эзлэхүүнээр	Төг/м³ 2,000.0
		Хэмжүүрээр хувьсах	Төг/ГЖ 19,266.4
		Хэмжүүрээр тогтмол	Төг/м³ 1,136.5
9	Дулааны эрчим хүчний үйлчилгээний тариф	40 м² хүртэлх талбайтай айл өрх	Төг/сар 3,000.0
		41 м²-ээс 80 м² хүртэлх талбайтай айл өрх	Төг/сар 5,000.0
		81 м²-ээс дээш талбайтай айл өрх	Төг/сар 10,000.0

12
Эрчим хүчний
ЗОХИЦУУЛАХ ХОРОО
ХУУЛБАР ҮНЭН

Хуулбар олгосон амжилтны гэрэл

21 02 38